

БУРХАН БАГШ

I БӨЛӨГ

БУРХАН ШАГЖАМУНИ

I

Бурхан багшийн амьдрал

1. Хималайн уулсын урд хормойг ороон урсах Рохини голын эрэг дээр оршигч, Шагжа омгийн улсын нийслэл Капилавасту балгаст Суддодана Гаутама буюу Ариун идээт хаан бээр амьдарч байжээ. Тэрбээр шулуун шударга, цэцэн мэргэн хэмээн алдаршиж, айлдсан болгоныг нь үг дуугүй дагах ард түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээжээ.

Хааны хатныг Маяа хэмээнэ. Тэрбээр мөнөөхи Шагжа омгийнхны үүсгэж буй болгосон хөрш зэргэлдээ орших нэгэн улс гүрний эзэн хааны нагац ахын охин буюу эзэн хааны үеэл дүү байжээ.

Хаан, хатан хоёр гэрлэснээс янагш хорь гаруй жил улирсан ч, тэдэнд үр заяасангүй. Нэгэнтээ хааны хатан цагаан заан баруун сугаар хэвлийд нь орж бие давхар болов хэмээн сонин зүүд зүүдлэв. Эзэн хаан болон ордныхон, мөн ард түмэн нь хоног өдрийг хуруу даран тоолж, мэндлэх хүүхдийг тэсэн ядан хүлээжээ. Бие хөнгөрөх цаг болоход хааны хатан ард түмнийхээ ёс заншлыг дагаж, төрсөн гэртээ амаржихаар явлаа. Зам зуураа Лумбини цэцэрлэгт алжаал тайлахаар түр саатжээ.

Ээлтэйхэн хаврын урин дулаан цаг тул эргэн тойрон үзэсгэлэнт сайхан ашока мод цэцэглэж байлаа. Хааны хатан цэцгээ дэлгэсэн модны мөчир таслах санаатай баруун гараа сунгатал хүү нь мэндлэв. Хатан, хүү хоёрыг ерөөн адислаж, эргэн тойрон дуу хуур эгшиглэн найрсав. Энэ бол 4 дүгээр сарын 8-ны өдөр байлаа.

Баярлаж хөөрсөн хаан, хүүдээ Сиддарта буюу "Хамаг тусыг бүтээгч" Артасиди хөвгүүн хэмээх утга бүхий нэр хайрлав.

2. Гэвч хаан баяр цэнгэлийн эцэст уй гашуу амсаж, хатан Маяа нь ертөнцийн мөнх бусыг үзүүлэв. Хатны охин дүү Махапражапати хан хүүг асран бойжуулах болсон аж.

Тэр хавиас холгүй орших нэгэн ууланд Асита хэмээх мэргэн даяанч амьдарч байв. Хааны ордныг тйрон гэрэл гэгээ сацрахыг тэрбээр хараад залран ирэхэд саяхан мэндэлсэн хан хүүг түүнд үзүүлжээ. "Том болоод хэрэв ордондо үлдвэл аугаа их хаан болж бүх ертөнцийг нэгтгэнэ, Харин ордноо орхиж даяан хийж, үнэнийг ухаарвал энэ ертөнцийг аврах заяатай Бурхан болно" гэж Асита өгүүлэв.

Хаан, мэргэн даяанчийн үгийг сонсоод эхлээд их баярласан ч, он жил улирах тусам хүү нь ордныг

Бурхан Шагжамуни

орхиж даяанч болж магадгүй гэсэн бодол сэтгэл зүрхий нь зовоож эхлэв.

Хан хүү долоон настайдаа ном судар үзэж, цэргийн эрдэмд суралцаж эхлэв. Хаврын нэгэн өдөр тэрбээр хаан эцэгтэйгээ хамт тосгонд очихоор явжээ. Тариачин газар хагалж буйг ажиж байснаа, анжис нь газрын хэвлийг ярахад гарч ирсэн өтийг шувуу тоншиж идэхийг харчихжээ. Тэрбээр саяхан үзсэн харсандаа гайхаж: "Ямар муухай юм бэ! Амьд нь амьдыгаа идэж байх юм!" хэмээн уулга алдаж модны сүүдэрт саатан сууж, гүн бодолд автав.

Хар нялхаараа эхийгээ алдсан, сая болохоор амьд нь амьдыгаа идэхийг харсан хан хүү амьдралын эмгэнэл гунигийг эрт ухааран таньж, эмзэг өрөвчхөн сэтгэлд нь гүн шарх суужээ. Энэ шарх сорви зулзган модны шарх цаг хугацаа улирах тусам улам ихсэх адил, харсандаа гайхаж: "Ямар муухай юм бэ! бодол төрүүлдэг болов.

Хүүгийнх нь зан ааш хувирч буйг анзаарсан хаан эцэг нь мэргэн даяанчийн хэлснийг санаж сандрав. Хаан бээр хүүгээ хөгжөөн баясгахын тулд бололцоотой бүхнээ хийжээ. 19 нас хүрмэгц нь хүүдээ Яшодхара нэртэй бөл дүүг нь эхнэр болгон авч өгчээ. Яшодхара бол хан хүүгийн эхийн төрсөн ах, Девадаха цайзанд суудаг Супрабуддха хааны охин байлаа.

3. Хан хүү арван жилийн турш найр наадам, баяр цэнгэлд умбаж Хавар, Намар, Борооны орднууддаа ээлжлэн амьдарч байлаа. Гэвч тэрбээр цаг үргэлж гүн бодолд автаж, амьдралын үнэнийг ухаарахыг эрмэлзэж байв.

"Ордны баян тансаг, цатгалан чинээлэг амьдрал, хүмүүсийг баясгах миний эрүүл саруул бие, залуу шндан нас ямар утга учиртай юм бэ? Хүмүүс өвчинд баригдаж, эцэст нь амьсгал хураах аж. Хэн ч үхлээс мултарч чадахгүй. Залуу нас, эрүүл саруул бие, амьдралын утга учир юунд оршино вэ?"

Хүн амьдарч байна гэдэг ямар нэг юмыг эрж байна гэсэн үг. Гэтэл нэг хэсэг нь бурууг, нөгөө хэсэг нь зөвийг хайна. Бурууг эрж хайгчид хэн бэ гэвэл өглөх, өвдөх, үхэх заяатай мөртлөө мөнхийн омголон залуу нас, мөнх амьдралыг хүсэгчид билээ.

Зөвийг эрэгч хэн бэ гэвэл энэ бүхнийг төөрөгдөл хэмээн ухаарч, өглөх, өвдөх, үхэх зэрэг амьдралын эрээн бараан бүхнээс эрхэм дээд зүйлийг эрэн хайгч юм. Би тэр бурууг л хүсч, бурууг эрэн хайж байна даа".

4. Олон жилийн турш ийнхүү хүнд хүчир бодолд автан, зүрх сэтгэл нь хатуу ширүүн тэмцлийн талбар болов. 29 нас хүрэхэд нь Рахула хэмээх нэртэй цорын

Бурхан Шагжамуни

ганц хүү мэндэлж, хан хүү ордноо орхин явахаар шийдэв. Чандаха хэмээх хөтөчөө дагуулаад Кантхака хэмээх хайртай агтандаа мордож ордноо орхин, энэ ертөнцтэй холбоогоо таслаж, нямба хийж суулаа.

Тэгтэл нэгэн рагшис түүнийг сорьж хэлсэн нь: "Чи ордондоо буцаж очоод хүлээсэн нь дээр. Удахгүй энэ ертөнц тэр аяараа чинийх болно". Хан хүү хашгирсан нь: "Рагшис чи эндээс тонил! Энэ ертөнцийн юуг ч би үл хүснэ". Түүнийг хөөн тонилгосныхоо дараахан хүүү лам болж, бадар барьж өмнө зүг оджээ.

Эхлээд хан хүү мэргэн даяанч Багавад бараалхаж түүний хатуу хориг дэглэм бүхий амьдралтай танилцав. Дараа нь Арада Калама, Удрака Рамапутрад бараалхаж бэрх хэцүү хатамжлалыг нь үзэж, тэдэнтэй адилхан даяан хийхийг оролджээ. Удалгүй ийм замаар эс гэгээрэхийг ухаарч, Магада улсад очжээ. Тэнд Гайя хотын дэргэдүүр урсдаг Ниранзана мөрний эрэгт нэгэн аглаг ойд очиж, биеэ зовоосон хатуухан сорилтыг эхэлжээ.

5. Өөрийнхөө бие бялдрыг хүнд ширүүн зовоон тарчлааж байлаа. Хожим нь түүний дурсан айлдсанаар, урьд өмнө нь үзэгдээгүй бэрх аргаар махбодоо зовоосон аж. Түүний өгүүлснээр, "Урьд өмнө нэг ч даяанч өөрийгөө тэгэж хатуу ширүүн

зовоож байгаагүй, одоо ч өөрийгөө тэгэж зовоож буй хүн байхгүй, ирээдүйд энэ ертөнцөөс халин одсон хэн боловч түүнээс илүү хатуу ширүүнээр өөрийгөө зовоож тарчлаахгүй" ажээ.

Ингэж өөрийгөө зовоосон ч хан хүү эрж хайснаа, хүсэж хүлээснээ эс олов. Тэрбээр 6 жилийн турш эр биеэ зовоосон энэхүү хатамжлалаа үл харамсан зогсоож, мөрний усанд угаал үйлдэн, Сужата хэмээх залуухан бүсгүйн гараас сүүтэй будаа авч хүртээд, ядарч сульдсан биеэ анагааж эхэлсэн байна.

Ойд түүнтэй цуг хатамжилсан таван даяанч, хан хүү сорилтыг давсангүй хэмээн сэтгэж, ганцааранг нь орхин өөр газар руу нүүн дүрвэжээ.

Хан хүү гав ганцаараа хоцорч модны сүүдэрт суугаад хэзээ л бол хэзээ үхэхээс буцахгүй, гүн бясалгалд автав. Тэрбээр сэтгэл шулуудан: "Миний цус хатвал хатаг. Миний мах ялзарвал ялзраг. Миний яс өмхөрвөл өмхрөг. Эндээс би хаашаа ч хөдлөхгүй" гэжээ.

Санаа сэтгэлд нь хэцүүхэн, ээдрээтэй тэмцэл эхэлжээ. Түгшүүртэй болоод зовлонтой бодлууд санаа сэтгэлийг нь үймүүлж, элдэв зүйлийн хий үзэгдлүүд цааш нааш үсчин, тэр нь илүү аймшигтай гэж хэлэхийн аргагүй жигшмээр дүрс сэтгэлд нь нэг нэгээсээ өрсөн ургана. Энэ бүхэн рагшисын явуулга

Бурхан Шагжамуни

байлаа. Хан хүү эдгээр явуулгатай тэмцэж, нэгийг нь ч зүгээр орхилгүй, дор нь нам дарж, хумхын тоос болгож байлаа. Энэ бол жирийн нэг тэмцэл бус, цус нөж урсаж, амьд махыг яснаас нь салган хуулж, яс хугарч байсан болохоор сэхэхийн төлөө тэмцэл байсан юм.

Гэвч энэ тэмцэл дуусч, тэнгэрт үүрийн цолмон гийж, шинэ өдөр эхэлснийг тунхаглан зарлахад хан хүүгийн сэтгэл санаа гэрэлтэн гялалзаж, тэрбээр гэгээрч Бурхан багш болов. Энэ баяр баясгалант үйл явдал хан хүүгийн 35 насан дээр арванхоёрдугаар сарын 8-ны өглөө тохиосон юм.

6. Энэ мөчөөс эхлэн хан хүү Бурхан багш Ялж төгс нөгчсөн, түүнчлэн ирсэн, Сайваар ажирсан, Амарлингуй оршигч, бүхнийг айлдагч, Чадагчийн эрхт, Шагжагийн арслан зэрэг олон нэртэй болсон бүлгээ.

Юуны түрүүн Шагжамуни зургаан жилийн турш цугтаа хатамжлан зовж байсан, эдүгээ Варанасийн Мригадавад амьдарч буй таван даяанч дээр очиж шашиндаа оруулжээ. Эхлээд тэд цэрвэн зугтаж байснаа сургаал айлдахы нь сонсож түүнд бүрэн итгэл найдвараа өгч, анхны шавь нар нь болов. Тэрбээр Ражагрихад байхдаа эзэн хаан Бимбасараг шашиндаа оруулжээ. Шагжамуни түүний ордонд заларч орон даяар ариун сургаалаа айлдаж эхлэв.

Хүмүүс цангахдаа ус, өлсөхдөө хоол хүсдэг лүгээ адил түүн рүү тэмүүлэн цувж байлаа. Эндээс гол шавь Шарибудари, Модгальяана нарыг олж, мөн хоёр мянга гаруй хүн түүнд шавь оржээ.

7. Шагжамуни 45 жилийн турш сургаалаа айлдаж 80 нас сүүдэр зооглов. Ражагрихаас Шравасти орох замдаа Вайсали хэмээх газар бие алжааж, гурван сарын дараа Нирванд орно гэдгээ хэлжээ. Тэгээд помлол сургаалаа айлдаж явсаар Пава хэмээх газар очиж, тэнд Чунда дархны барьсан хоолыг амсаад овчин нь үгдрэв. Өвчин зовлонд шаналж, улам ядарч сульдсан ч тэрбээр цаашаа Кусинагара руу явжээ.

Тэрбээр Кусинагара балгасын захад сала хэмээх ойд очиж, хоёр өндөр модны хоорондох газар хэвтэв. Газар дээр ийн хэвтэж байхдаа ч шавь нартаа сургаал айлдсаар байлаа. Чингээд агуу их сургаал номлогч Бүрханы үүргээ бүрэн гүйцэд биелүүлж дуусаад алгуурхан Нирванд оров.

8. Шагжамуни Нирван дүрийг үзүүлсний дараа Кусинагара балгасын иргэд гүн их уй гашууд автжээ. Бурханы хайртай шавь Анандын айлдсанаар тэд, багшийнхаа шарилыг ариун галд өргөв.

Бурхан Шагжамуни

Ажатасата хаан, мөн Энэтхэгийн 7 хаан Шагжамунийн чандраас хүртээхийг хүссэнд Кусинагара балгасынхан татгалзаж, чингээд дайн дэгдэв. Гэвч Дрона мэргэний зөвлөсний дагуу Бурхан багшийн чандрыг найман улсын дунд хуваасан аж. Шагжамунийн чандраас өөр олон улс, хүмүүс ч хүртжээ. Бурханы ариун шарилыг тэд нүдний цөцгий мэт хайрлан хамгаалдаг болов. Түүнийг хадгалж байхын тулд бурханы шашны арван сүм босгосон аж.

II СҮҮЛЧИЙН НОМЛОЛ

1. Кусинагарагийн ойролцоо сала хэмээх ойд Шагжамуни сүүлчийн удаа сургаалаа айлдсан аж.

Тэрбээр шавь нартаа хандаж номлосон нь: Та нар өөрсдөө бусдын төлөө ассан гэрэл болцгоо! Та нар өөрсдөө өөрсдийнхөө түшиг тулгуур болж, хэнд ч бүү найдаж бай! Миний сургаал та нарт гэрэл гэгээ, түшиг тулгуурын аль аль нь болог! Бусад сургаал, номыг түшиж тулахаас цээрлэ!

Бохир биеэ хараад бохирыг нь ухаарч, хэзээ ч гоё чамин хувцас бүү хүсч бай! Баяр цэнгэл, зовлон

зүдгүүрийн аль аль нь зовлонгийн шалтгаан гэдгийг ухаарч, цэнгэл жаргалд автахыг цээрлэ! Сэтгэл санаагаа шинжээд тэнд өөрийн чинь "Би" бээр байхгүйг ойлгож, сэтгэлийн хөдөлгөөндөө бүү хуурт! Тэр цагт та нар зовлон зүдгүүрээс үүрд ангижирна. Намайг энэ ертөнцөөс халин одсоны дараа ч гэсэн та нар, миний сургаалыг үнэн зөв даган мөрдөж чадвал, жинхэнэ үнэнч шавь нар минь болно.

2. Миний номлосон бүх сургаалыг цаг ямагт санаж яв, тэдгээрийн тухай үргэлж бодож бай, утга учрыг нь онохыг хичээ, ямар ч үед тэдгээрээс бүү татгалз. Хэрэв миний сургаалыг үнэн зөв дагавал та нар жинхэнэ жаргалыг амсана.

Миний сургаалын хамгийн гол нь санаа сэтгэлээ удирдаж чаддаг болоход оршино. Өөрийнхөө хүслийг хазаарлан номхотгож, өөрийгөө ялж сурах хэрэгтэй. Биеэ зөв авч явж, зөв үйл хийж, сэтгэл санаагаа ариун байлгаж, хэлсэн үгэндээ эзэн болох ёстой. Шунал хүслээсээ татгалзаж, уур хилэнгээ номхотгож, нүглээс зайлж, амьдрал мөнх бусыг үргэлж санавал зохино.

Зүрх сэтгэлд чинь хүсэл шунал, нүгэл хилэнц орогновол, түүнийг ялах хэрэгтэй. Зүрх сэтгэлдээ бүү захирагд, харин зүрх сэтгэлийнхээ эзэн болох

Бурхан Шагжамуни

хэрэгтэй.

Зүрх сэтгэл нь хүнийг бурхан ч болгоно, буг ч болгоно. Төөрөлдсө хүн шулам, гэгээрсэн хүн бурхан болно. Санаа сэтгэлээ ариун байлгаж, буяны замаасаа бүү хазай.

3. Миний сургаалыг дагаж бие биетэйгээ энх амгалан, эвтэй найртай амьдарцгаа, нэг нэгнийгээ хүндэлж бай, хоорондоо бүү хэрэлдэж маргалд. Ус, сүү лүгээ адил бие биентэйгээ зохицож бай, ус, тос лугаа адил нэг нэгийгээ бүү түлх.

Миний сургаалыг хамтдаа дагаж мөрд, сурч ухаар, хамтдаа төгс төгөлдөр болж, нэг нэгэндээ тусалж, буяны зам мөрийн баяр баясгалангаа хуваалцаж бай. Хэрэггүй юмыг эс шохоорхож, ашиггүй юманд цагаа бүү зарцуул, гэгээрэн гийхийн цэцэг, буяны зам мөрийн үр жимснээс хүртэж яв.

Би бээр, та нарт өгч буй сургаалаа гэгээрснээр ухаарсан юм. Та нар энэ сургаалыг баримталж, хатуу мөрдөх хэрэгтэй.

Миний сургаалыг дагахгүй бол миний дэргэд байсан ч намайг олж харахгүй. Харин сургаалыг минь дагавал надаас асар хол байсан ч үргэлж цуг байна.

4. Шавь нар минь, удахгүй миний цаг болох гэж

байна. Та нараасаа салах цаг ойртлоо. Гэвч та нар гуньж гутарч үл болно. Амьдрал мөнх бус, энэ ертөнцөд төрсөн хэн боловч үхнэ. Би бээр үхэхэд миний бие модон тэрэг лүгээ адил өмхөрч алга болно. Ингэж хүний оршин тогтох мөнх бус гэдгийг дахин батална.

Бүү гуньж гутарцгаа. Ертөнцөд ганц ч мөнх юм үгүйг ухаарч, хүний оршин тогтнохын утга учрыг онож мэдэцгээ. Хувирч өөрчлөгддөг бүхнийг үл хувиргахыг бүү хүс. Энэ хүсэл хэзээ ч бүтэж биелэхгүй.

Энэ ертөнцийн тачаал шуналын шулам хэзээд бэлэн байдаг бөгөөд сонор сэрэмж чинь сулармагц та нарыг эзэмдэж эрхэндээ оруулна. Хэрэв гэрт чинь хорт могой үүрлэвэл, тэр амьтныг хөөж гаргахаас нааш амар амгалан нойрсож чадахгүй шүү дээ.

Ертөнцийн тачаал шуналын шулмыг хөөж зайлуулах хэрэгтэй. Ертөнцийн хүсэл шуналын могойг хөөн гаргах хэрэгтэй. Сэтгэл санаагаа та нар сонор соргог хамгаалах ёстой.

5. Шавь нар минь, миний цаг ирлээ. Гэвч энэ бол миний бие махбодын үхэл гэдгийг бүү мартаарай. Хүн биеийг эцэг эхээсээ олдог, олсон биеэ хоол хүнсээр торддог учир, тэр нь эмгэгт хялбархан өртөж, шарх сорви авах нь ч түргэн, эцэстээ эвдэрч нурах л

Бурхан Шагжамуни

хувь тавилантай юм.

Бурханы мөн чанар бие махбодод нь бус, гэгээрэхэд нь оршино. Бие махбод эвдэрч нурна, гэтэл гэгээрэл нь Номын үнэн болон үйл хэрэг нь мөнх оршиж байдаг. Бие махбодыг минь харж буй хүн бус, харин сургаал номыг минь ухаарч буй хүн л намайг олж үзнэ.

Амьсгал хураасны минь дараа миний орхиж үлдээсэн ном та нарын багш болно. Та нар түүнийг хайрлан хадгалж, тэгснээр надад үнэнч зүтгэх ёстой.

Шавь нар минь, амьдралынхаа сүүлчийн 45 жилд би бээр айлдах ёстой болгоноо айлдсан, хийх ёстой бүхнээ хийсэн. Одоо та нарт үзүүлээгүй нууц надад байхгүй. Миний дотор ч тэр, миний гадна ч тэр хаана ч байхгүй. Би Номлох бүхнээ номлосон.

Шавь нар минь, миний цаг ирлээ. Би бээр Нирванд орлоо. Энэ бол миний сүүлчийн номлол юм.

II БӨЛӨГ МӨНХИЙН БУРХАН

I БУРХАНЫ НИГҮҮЛСЭНГҮЙ СЭТГЭЛ, ӨРГӨСӨН ТАНГАРАГ

1. Бурханы амин сүнс бол Дээд зэргийн нигүүлсэнгүй, дээд ээргийн энэрэнгүй сэтгэл билээ. Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэл нь ямар ч үнэ цэнээр хамаагүй бүх хүнийг аврах гэсэн Бурхан багшийн хүслэн юм. Дээд зэргийн энэрэнгүй сэтгэл нь хүмүүстэй хамт өвдөж зовох, тэдэнтэй хамт зовлон зүдгүүрийг туулах гэсэн Бурхан багшийн хүслэн юм.

Элбэрэлт эх лүгээ адил Бурхан багшийн сэтгэл нь хэнийг ч гэсэн цаг үргэлж анхааран хамгаалж, хооллож, аюултай мөч тулгарахад авардаг юм. Бурхан багш хүмүүсийг хэзээ ч үл орхино. Тэрбээр хүмүүс зовоход өөрөө адилхан зовж, хүмүүс баярлаж баясахад Өөрөө адилхан баясах бүлгээ.

Бурхан багш хүмүүст Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг. Хүмүүс энэхүү Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлийг мэдэрч түүнд сүсэглэн биширч эхэлдэг юм. Сүсэг бишрэл нь гэгээрэх замд хөтөлнө. Үлгэрлэвээс эх хүн үрээ хайрлах сэтгэлээр эх болсныгоо мэддэгтэй энэ нь агаар нэгэн буй. Эхийн хайр ивээлээр үр нь ч гэсэн тав тухтай, бүлээн

Мөнхийн Бурхан

дулаан амгалан тайван өсч бойжино.

Гэвч хүмүүс Бурхан багшийн энэ амин сэтгэлийг үл ухаарах бүлгээ. Тиймээс ч хорвоогийн тачаал шуналд олзлогдон, шаналал зовлонд автаж, төөрөлдөн тарчилна. Нүгэлт үйлийн үрээ даахгүй зовж, төөрөгдлийн нэг уулнаас нөгөө ууланд хэсүүчилнэ.

2. Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл зөвхөн энэ ертөнцийн амьдралаар үл хязгаарлагдана. Энэ чанар нь мөнхийн бөгөөд аливаа хил хязгаарт үл баригдана. Нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл нь хүмүүс энэ ертөнцөд мэндэлж, төөрөлдөн зовж, шаналан тарчилсаар амьсгал хураадаг болсон цагаас эхлээд оршиж байсан юм.

Бурхан багш хүмүүсийн ертөнцөд тэдний хамгийн ойр дотно дүрийг олон төрж, тэднийг аврахын тулд бололцоотой бүхнийг хийдэг.

Бурхан багш Шагжа овгийн хааны гэрт хан хүүгийн дүрийг олон мэндэлж, хожим нь ордноо орхин явж, Өөрийн биеийг хатамжлан зовоож, дараа нь гэгээрч, ард түмэнд сургаалаа номлож, эцэст нь амьсгал хурааж, ингэснээр үхлийн мөн чанарыг хүмүүст үзүүлсэн юм.

Хүмүүсийн төөрөгдөл зах хязгааргүй, Бурхан багшийн ариун үйл хэрэг ч эцэс төгсгөлгүй бүлгээ.

Хүмүүсийн нүгэл хилэнцэд хил хязгаар үгүй бол, Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлд бас хил хязгаар үгүй.

Учир иймээс гэгээрэх зам мөрд орохдоо Бурхан багш дөрвөн их тангараг өргөжээ. Нэгдүгээрт, бүх хүнийг аварна. Хоёрдугаарт, бүх төөрөгдлийг устгана, Гуравдугаарт, бүх ном сургаалыг үзэж судална. Дөрөвдүгээрт, заавал гэгээрнэ Энэхүү дөрвөн их тангарагыг өргөж Бурхан багш Өөрийн гэгээрэх замыг эхэлжээ. Замын эхэнд энэ дөрвөн тангарагыг өргөсний учир нь Бурхан багшийн сэтгэл бол Дээд зэргийн нигүүлсэнгүй, энэрэнгүй, хүмүүсийг өрөвдөн хайрлаж, аврахын элгэн халуун хүслэн гэдэгт л оршино.

3. Юуны түрүүн Бурхан багш төгс төгөлдөр чанарыг эзэмшихийн тулд бусад амьтны амь хороохын нүглээс салж, хүмүүст урт удаан наслахын ерөөл айлджээ.

Бурхан багш хулгай хийх нүглээс салж, хүмүүс хүссэн бүхнээ хүртэж байхын ерөөл дэвшүүлжээ.

Бурхан багш бие махбодын шунал тачаалаас ангижирч, хүмүүс нэг нэгэндээ нүгэл хүсэхийг тэвчиж, цангах, өлсөхийн зовлонгоос ангижрахын ерөөл айлджээ.

Мөнхийн Бурхан

Бурхан багш төгс төгөлдөр болохын тулд худал хэлэхийн нүгэлээс салж, зөвхөн үнэнийг хэлдэг хүмүүсийн санаа сэтгэлийн амгалан тайван байдлыг ухаарах ерөөлийг айлджээ.

Бурхан багш хов живийн нүглээс ангижирч, хүмүүс нэг нэгтэйгээ найртай, эв түнжинтэй амьдарч, зөв зам мөрийг хамтран хайж олохын ерөөл айлджээ.

Бурхан багш муу үг хэлэх нүглээс салж, хүмүүсийн санаа сэтгэл байнга энх амгалан, амар тайван байж, түгшүүрт үл автахын ерөөл айлджээ.

Тэрбээр дэмий чалчих дутагдлаас салж, хүмүүс нэг нэгэндээ анхаарал халамж тавьж байхын ерөөл айлджээ.

Бурхан багш төгс төгөлдөр чанар эзэмшихийн тулд хармын сэтгэлээс салж, хүмүүс өглөгч байхын ерөөл айлджээ.

Тэрбээр үзэн ядах сэтгэлээс ангижирч, хүмүүс бие биедээ энэрэнгүй хандаж байхын ерөөл айлджээ.

Бурхан багш харанхуй мунхагаас ангижирч, хүмүүс учир шалтгааны хуулий үл ойшоон төөрөлдөхгүй байхын ерөөл айлджээ.

Иймээс ч Бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл бүгдэд зориулагдсан юм. Бурхан багш бүгдэд гагцхүү жаргалыг хүсэн ерөөдөг билээ. Бурхан багш эцэг эхийн хайраар хүн төрөлхтнийг энэрэн хайрлаж, төөрөгдлийн далайг эсэн мэнд даван туулах ерөөл айлддаг юм.

II БУРХАНЫ АВРАЛ, ТҮҮНИЙ ТУСЫН МУТАР

1. Гэгээрлийн эрэг дээр зогсч буй Бурхан багшийн дуу хоолой төөрөгдлийн далайд живж байгаа хүмүүсийн сонорт хүрдэггүй. Тиймээс Бурхан багш Өөрийн биеэр төөрөгдлийн далайд орж, хүмүүст туслахын тулд мутраа сунгасан юм.

Нэгэн сургамжит домогт өгүүлснээр, эрт урьд цагт баян хүн амьдарч байжээ. Нэг удаа гэрт нь гал гарчээ. Тэрбээр ажил хэргээр яваад эзгүй байсан тул буцаж ирээд галд автсан гэрээ үзжээ. Баян хүн галд автсан байшин дотор тоглож байсан хүүхдүүдээ дуудахад цаадуул нь гал гарсныг анзааралгүй тоглосоор байлаа.

Эцэг нь хүүхдүүдээ хандаж хашгирсан нь: “Хүүхдүүдээ амиа аварцгаа! Наад байшингаасаа шалавхан гарцгаа!” гэхэд хүүхдүүд нь сонссонгүй.

Мөнхийн Бурхан

Айж сандарсан эцэг дахин хашгирсан нь: “ Хүүхдүүдээ би хөөрхөн тоглоом авчирлаа. Май, гарч ирээд авцгаа”. Тоглоомын тухай сонссон хүүхдүүд шатаж буй байшингаас гүйн гарч аврагджээ.

Бидний амьдрал шатаж буй байшин лугаа адил билээ. Гэвч хүмүүс байшин нь галд автсаныг эс анзааран, амь насаа алдах гэж буйгаа мэдэлгүй шатаж буй байшиндаа амьдарч байдаг. Иймээс Бурхан багш Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлийг үзүүлж, хүмүүсийг аврахын тулд бололцоотой бүхнийг байнга хийдэг юм.

2. Өөр нэгэн сургамжтай домогт өгүүлснээр, эрт цагт нэгэн баян хүний ганц хүү, эцгийн гэрийг орхин хорвоо ертөнцөөр хэрэн хэсч яваад золгүй явдалтай учирч ядуу хоосны туйлыг үзжээ.

Эцэг нь орон гэрээ орхиж, тэнэмэл хүүгийнхээ эрэлд гарчээ. Тэрбээр хүүгээ газар сайгүй хайгаад хаанаас ч олсонгүй.

Чингээд олон арван жил өнгөрөв. Ядуурч хоосорсон хүү нь баян чинээлэг эцгийнхээ сууж байсан хотод санамсаргүй очжээ.

Хүүгээ таньсан аав нь баярласандаа дэвхцэж, түүний араас зарцаа илгээв. Гэвч хүү хэлүүлсэнд нь

үл итгэв. Хууртаж мэхлүүлэхээс айсан хүү нь аав дээрээ очсонгүй.

Чингээд эцэг нь зарцаа дахин илгээж сайн хөлс төлье, манайд ирж ажиллаач хэмээн хэлүүлжээ. Хүү нь энэ мэхэнд гэнэдэн зөвшөөрч аавынхаа гэрт зарц болов.

Баян эцэг нь гэртээ ажиллаж буйгаа үл анзаарах хүүдээ улам бүр хариуцлагатай ажил даалгаж, нэгэнтээ үнэт баялгаа хадгалсан агуулахын түлхүүр өгчээ. Тэгсэн ч хүү нь эцгийнхээ гэрт ажиллаж буйгаа ухаарсангүй.

Хүү нь дуулгавартай бөгөөд хөдөлмөрч болсонд эцэг нь учиргүй баярлаж байлаа. Тэрбээр удалгүй амьсгал хураах цаг ирэхийг мэдэж, нэг өдөр төрөл төрөгсөд, найз нөхөд, ойр дотныхноо дуудан цуглууж хэлсэн нь: "Энэ хүү миний төрсөн үр юм. Олон жилийн турш эрж хайсан хүү минь юм. Энэ мөчөөс эхлэн хураасан бүх эд баялаг минь түүнд шилжин очно" гэв.

Үүнийг сонссон хүү гайхаш алдаж: "Би бээр эцгээ олоод зогссонгүй, санаандгүй энэ бүх баялгийн эзэн болдог байж" гэв.

Энэ сургаал — домогт баян хүн нь бурхан

Мөнхийн Бурхан

багшийг, төөрсөн хүү нь нийт хүмүүсийг төлөөлж байгаа юм. Эцгийн хайр нь цорын ганц хүүдээ хандсан лугаа адил бурхан багшийн нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэл нь энэ газар дэлхий дээрх бүх хүнд хандана. Бурхан багш хүн бүрийг хүү шигээ бодон сургаж, гэгээрэхийн баялгийг өгч баян болгодог юм.

3. Бүх хүмүүсийг хүү шигээ хайрладаг Бурхан багшийн Дээд зэргийн энэрэнгүй сэтгэл бүгдэд ижил оногдох боловч, хүн бүрийн зан араншин өөр байх лугаа адил тэднийг аврах арга зам ч өөр буй. Зүйрлэвэл, бороо нь бүх өвс ногоо, мод цэцгийг ижилхэн усалдаг боловч өвс ногоо, мод цэцэг бүр түүнээс өөрийн хувийг янз янзаар хүртэх бүлгээ.

4. Эцэг эх хичнээн ч олон үр хүүхэдтэй байсан, цугааранд нь адил тэгш, ойр дотно ханддаг. Тэдний дундаас нэг нь өвдөж зовбол түүнийг бусдаас илүү хайрлах бүлгээ.

Үүн лүгээ адил Бурхан багшийн дээд зэргийн энэрэнгүй сэтгэл бүгдэд ижилхэн хүрэх боловч, Хүнд хүчир нүгэл үйлдэж, мунхгаасаа болж зовж шаналж буйг нь Тэрбээр илүү хайрлаж, илүү энэрдэг юм.

Нар зүүнээс мандахдаа харанхуйг сарниаж, газар дээр буй бүхэнд гэрлээ тэгшхэн хүртээж тэтгэх адил Бурхан багш хүмүүсийн дунд орж нүглийг арилган,

буяныг дээдлэн үржүүлж оюун ухааны гэрлийг түгээж, мунхгийн харанхуйг арилгаж, хүмүүсийг гэгээрэх зам мөрд хөтөлдөг юм.

Бурхан багш бол халамжит эцэг, нигүүлсэнгүй эх юм. Бурхан багш нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлийн үүднээс энэ дэлхийн бүх хүний сайн сайхны тулд хүчин зүтгэдэг юм.

Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл үгүйгээр хүмүүс яагаад ч аврагдаж чадахгүй. Хүмүүс цугаараа Бурхан багшийн хүүхэд тул өөрсдийг нь аврахаар сунгасан Бурхан багшийн мутарт мөргөх хэрэгтэй.

III **МӨНХИЙН БУРХАН**

1. Бурхан багш хан хүү болж мэндэлсэн, дараа нь даяанч болохоор ордноо орхин явсан, чингээд гэгээрсэн гэж хүмүүс боддог. Гэтэл үнэн хэрэг дээрээ Бурхан багш энэ ертөнцөд хэзээ ч байж байдаг. Түүнд эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй.

Мөнх орших Бурхан багш хүн бүрийг сайн мэдэх бөгөөд хүмүүсийг бололцоотой бүх аргаар авардаг.

Бурхан багшийн номлодог мөнхийн номд худал

Мөнхийн Бурхан

Хуурмаг зүйл үгүй. Бурхан багш энэ ертөндөд буй бүх юмсыг яг байгаагаар нь мэддэг, мэддэгээ ч хүмүүст зааж номлодог.

Ертөнцийн бүх юмсыг яг байгаагаар нь танин мэдэх хэцүү. Учир юун гэвэл энэ ертөнцөд зөв мэт санагдаж буй юм нь үнэн хэрэг дээрээ буруу байдаг. Харин буруу мэт санагдсан нь зөв байдаг. Мунхаг хүмүүс энэ ертөнцийг ухааж ойлгож чадахгүй.

Гагцхүү Бурхан багш л бүх юмыг байгаагаар нь ухаарч чадна. Учир иймээс Тэрбээр энэ зөв, тэр буруу гэж хэлдэггүй, энэ сайн, тэр муу гэж ярьдаггүй, харин байгаагаар нь яг онож хэлдэг.

Бурхан багш сургах нь: “Бүх хүн зан ааш,үйл хэрэг, сүсэг бишрэлийнхээ дагуу буян хийх ёстой”.

2. Бурхан багш гагцхүү үгээр бус үйл хэргээрээ зааж сургана. Хэдийгээр Бурхан багшийн амьдрал эхлэл үгүй, төгсгөл үгүй боловч Тэрбээр тачаал шуналдаа автан амьдарч буй хүмүүсийн нүдийг нээж өгөхийн тулд, Өөрийн үхлээр хүний мөнх бусыг харуулахын тулд үхдэг.

Үлгэрлэвэл манайд олон хүүхэдтэй нэг оточ буй. Нэгэнтээ тэрбээр хөрш гүрэн рүү явжээ. Түүний эзгүйд хүү нь хор ууж, бие нь мууджээ. Хол газраас эргэж ирсэн оточ айн сандарч тэдэнд эм тан өгөв.

Эвдрээгүй хөөрхөн ааштай хүүхдүүд нь өгсөн эмийг ууж эдгэхэд, зан чанар эвдэрсэн нь эм уухаас татгалзжээ.

Хүүхдээ эмчлэхийн тулд оточ эцэг заль хэрэглэхээр шийдэж, тэдэнд хэлсэн нь: "Би урт удаан аян замд гарах боллоо. Нас сүүдэр өндөр тул хэзээ амьсгал хураахаа мэдэхгүй. Хэрэв намайг ҮХСЭН гэж дуулвал миний үлдээсэн эмийг ууж эдгээрэй". Чингээд тэрбээр холын аянд дахин гарчээ. Тэрбээр зарцаа замаасаа буцааж өөрийгөө таалал төгссөн гэж хүүхдүүддээ хэлүүлжээ.

Үүнийг дуулсан хүүхдүүд нь гүн их уй гашууд автаж: "Эцэг маань нас барлаа. Одоо биднийг өмгөөлж хамгаалах хүнгүй болов" хэмээн уйлалдав. Уй гашууд автаж, гуьнж гутарсан хүүхдүүд эцгийнхээ захиасыг санаж үлдээсэн эмийг нь ууж цугаараа эдгэрчээ.

Оточ эцгийн худал хэлснийг буруушааж болох уу? Бурхан багш энэ оточ лугаа адил бүлгээ. Хүслийн хүлээсэнд баригдаж сохорсон хүмүүсийг аврахын тулд Тэрбээр энэ ертөнцөд төрөх, үхэх хоёулаа буйг хүмүүст үзүүлсэн юм.

III БӨЛӨГ

БУРХАН БАГШИЙН ДҮРҮҮД, ТҮҮНИЙ БОДЬ ЧАНАРУУД

I

БУРХАН БАГШИЙН ГУРВАН ДҮР

1. Бурхан багшийг ямар нэгэн дүр, хэлбэрээс хайж олохыг эрмэлзэх хэрэггүй. Дүр, хэлбэрийн аль нь ч жинхэнэ Бурхан багш биш. Жинхэнэ Бурхан багш бол гэгээрлээс өөр юу ч биш. Гэгээрсэн хүн л жинхэнэ Бурхан багшийг олж харна.

Хэрэв хэн нэгэн нь Бурхан багшийн гайхамшигтай сайхан дүр зургийг үзчихээд Бурхан багшийг харлаа гэвэл энэ нь мунхаг нүдний гэм юм. Бурхан багшийн жинхэнэ дүр хэнд ч харагдахгүй. Ямар ч өнгө будгаар Бурхан багшийг дүрсэлж, ямар ч үг, найруулгаар Бурхан багшийн дүрийг тодорхойлж болохгүй.

Дүр төрхтэй л бол тэр нь Бурхан багш биш юм. Бурхан багш дүр төрхгүй. Үүний сацуу Бурхан багш гайхамшигтай сайхан бүх дүрээр илэрнэ.

Бурхан багш өөрийгөө ямар ч хэлбэрээр илэрхийлсэн, түүнээс үл шалтгаалан, хэн нэгэн нь Бурхан багшийг ноттой олж үзвэл энэ нь тэрбээр Бурхан багшийг харах чадвартай боллоо гэсэн үг ээ!

2. Бурхан багшийн бие цогцос нь гэгээрэл буюу эвдэрч нурахыг мэдэх мөнхийн бүтээл туурвил юм.

Энэ бол хоол хүнсээр тэжээгддэг бие махбод бус, харин тэр чигээрээ оюун ухаан бүхий мөнхийн цогцос юм. Тэр цогцос айх эмээх, өвдөж зовохын алийг ч үл мэднэ. Тэр цогцос мөнхийн хувиршгүй чанартай.

Тиймээс Бурхан багш хэзээ ч үл эвдэрнэ. Гэгээрэл мөхөөгүй цагт Бурхан багш үл мөхнө. Гэгээрэл нь хүмүүсийг сэхээрүүлэгч Бурхан багшийн ертөнцийг буй болгогч оюун ухааны гэрэл гэгээ маягаар илэрнэ.

Эл ҮНЭНИЙГ таньж мэдсэн хүн Бурхан багшийн хүү юм уу, охин нь болж, Бурхан багшаас сургаалыг нь хүртэж, тууштай даган мөрдөж, хойч үедээ уламжлуулан өвлүүлж чадна. Бурхан багшийн хүч чадлаас илүү гайхамшиг үгүй.

3. Бурхан багш гурван цогцостой. Нэг нь Дхармакая буюу Бурхан багшийн жинхэнэ мөн чанар юм. Хоёр дахь нь Самбхогакая буюу Бурхан багшийн дотоод нөөц хүч юм. Гурав дахь нь Нирманакая буюу Бурхан багшийн илрэх хэлбэр юм.

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

Дхармакая бол Ном өөрөө мөн. Ном нь үнэн болон үнэнийг онож гэгээрсэн оюун ухаан хоёрын нэгдэн нийлэхийн нэр юм.

Ном бол Бурхан багш өөрөө мөн. Бурхан багш тодорхой өнгө, хэлбэргүй болохоор Тэрбээр хаанаас ч ирдэггүй, хаашаа ч явдаггүй. Хаанаас ч ирдэггүй хаашаа ч явдаггүй учир Тэрбээр хаа сайгүй оршино. Зах хязгааргүй тэнгэр огторгуй лугаа адил Тэрбээр бүхний болон бүгдийн дээр оршино.

Бурхан багш байдаг гэж хүмүүс боддогоос Бурхан багш буй юм бус. Бурхан багшийг мартдагаас Бурхан багш алга болдог юм биш. Тэрбээр хүмүүс баярлаж баясахад ирдэг, залхуурч лазагнахад явдаг ч юм биш. Бурхан багш, хүмүүс юу бодож, мэдэрдэгээс үл шалтгаалан энд тэнд, хаа сайгүй оршино.

Бурхан багшийн бие цогцос бүх сав шимийн ертөнцийг дүүргэн, хаа сайгүй оршино. Хүмүүс түүний тухай юу ч бодсон Бурхан багшийн цогцос мөнхийн чанартай юм.

4. Самбхогакая бол тодорхой хэлбэргүй Дхармакая Бурханы илрэл юм. Зовж зүдэрсэн олон амьтныг аврахын тулд Тэрбээр ямар нэгэн дүр төрхөнд хувиран тэдний дунд буй болж, тэдний төлөө залбирч, махбодоо хатамжлан тарчлааж, Өөрийн

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

ариун нэрийг нэрлэж, хүмүүсийг аврал өөд дагуулан явдаг.

Энэхүү Бурханы мөн чанар Дээд зэргийн нигүүлсэнгүй сэтгэлд оршино. Тэрбээр хүмүүсийг бололцоотой бүх аргаар аварна. Тэрбээр бүхнийг шатаагч гал лугаа адил ертөнцийн тачаал шуналын түлээ модыг шатааж дуусгана. Тэрбээр тоос арилгагч салхи лугаа адил төөрөгдлийн тоосыг сарниан замхруулна.

Нирманакая бол өмнө нь хэнбугай байгаагаас шалтгаалан тохирсон дүрийг олж хүмүүсийг аврахаар бууж ирдэг Бурхан юм. Тэрбээр энэ ертөнцөд мэндэлж, ертөнцийн амьдралыг огоорон орхиж гэгээрдэг юм. Тэрбээр бололцоотой бүх аргаар хүмүүсийг зөв замд нь оруулахын тулд номлон сургаж, тэдэнд өвчин зовлон, үхэл хагацлыг үзүүлэн сэрэмжилдэг.

Бурхан багшийн язгуур бие цогцос нь Дхармакая юм. Гэвч хүмүүс олон янзын зан араншинтай тул, Тэрбээр олон дүр төрхөд хувилж тодордог. Хэдийгээр Бурхан багшийг эрж хайж буй хүмүүс санаа сэтгэл, биеэ авч явах онцлог, авьяас чадвараасаа шалтгаалан Бурхан багшийн олон дүрийг үзэж хардаг боловч Бурхан багш тэдэнд нэг л үнэнийг номлодог.

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

Бурхан багшийн бие цогцос гурван өөр цогцост хуваагддаг ч ганцхан зорилгод хүрэхийн тулд чингэдэг юм. Эл зорилго хүмүүсийг аврахад оршино.

Бурхан багшийн эцэс төгсгөлгүй мөнхийн бие цогцос нь хорвоо ертөнцөд, хаа сайгүй буй болдог ч, Бурхан багш бие махбодгүй учир энэ цогцос Бурхан багш бус юм. Бурхан багшийн бие цогцос нь гэгээрэл юм, энэ ертөнцөд гэгээрэл бүхнийг дүүргэнэ. Бурхан багш үнэнийг ухаарсан хүний өмнө завал буй болдог.

II

БУРХАН БАГШ БУЙ БОЛОХ НЬ

1. Бурхан багш энэ ертөнцөд тодрох нь ховор. Одоогоор энэ ертөнцөд Бурхан багш нэгэнт гэгээрч, Номоо номлож, эргэлзлийн тор, шунал хүслийн үндсийг таслаж, нүглийн нүх уурхайг хаан таглаж байна. Тэрбээр энэ ертөнцөд ямар ч саад бэрхшээлгүй, эрх чөлөөтэй явж байна. Бурхан багшийг хүндэтгэн биширч, энэрэн хайрлахаас илүү дээд буян үгүй.

Бурхан багш Номоо номлож, хүмүүст жинхэнэ зол жаргал хайрлахын тулд хорвоод мэндэлдэг. Бурхан багш зовж шаналсан олон амьтныг гаргуунд нь орхиж чадахгүй учраас зовлонгоор дүүрсэн энэ

Бурхан ертөнцөд өөрөө залардаг.

Үнэн байдаггүй, худал хуурмаг явдал ноёрхдог энэ замлинд хүмүүс хүслийнхээ эргүүлэгт живж, бие бялдар, зан суртахууны хувьд ялзардаг. Энд амьдрал нүд ирмэх зуур өнгөрөх тул Ном номлоход бэрх байдаг. Гагцхүү хүмүүст Дээд зэргийн энэрэнгүй сэтгэлээр ханддаг болоод Бурхан багш эдгээр хэцүү бүхнийг давдаг юм.

2. Бурхан багш энэ ертөнцөд Хүн бүхний хамгийн ойр дотны анд нөхөр юм. Тэрбээр хорвоогийн шунал тачаалын хүнд ачаан дор зовж зүдэрсэн хэн нэгнийг олж харвал, хүнд ачааг нь Өөрийн нуруунд үүрнэ.

Бурхан бол энэ ертөнцийн жинхэнэ багш юм. Тэрбээр төөрөлдөн зовсон мунхаг хүнийг олж харвал оюун ухааны гэрлээр нүдний гэмийг нь арилгаж харанхуй мунхгийг нь сарниана.

Тугал эхээсээ нэг ч алхам холдохгүйн адил Бурхан багшийн сургаалыг таньж мэдсэн хүн Түүнээс холдож үл чадна. Учир нь түүний сургаалыг сонсох нь хэзээд баяр баясгалан төрүүлнэ.

3. Сар шингэхэд хүмүүс сар далд орлоо, сар мандахад сар гараад ирлээ гэлцдэг. Гэтэл тэнгэр огторгуйд сар үргэлж оршиж буй бөгөөд хэзээ ч далд

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

орж, ил гарч ирдэггүй. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Бурхан багш мөнх оршдог. Тэрбээр төрдөг ч үгүй, үхдэг ч үгүй. Тэрбээр зөвхөн хүмүүсийн нүдийг нээж, үнэнийг үзүүлэхийн тулд төрж, үхдэг.

Хүмүүс хавирган сар, тэргэл сар гэж ярьдаг. Үнэн хэрэг дээрээ сар ихсэх ч үгүй, багасах ч үгүй, үргэлж тэргэл хэвээр л буй. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. эрбээр үл төрж, үл үхнэ. Хүмүүс л Түүнийг төрж, үхэж байна гэж бодмуй.

Сар бүхнийг, бүгдийг гэрэлтүүлнэ. Хот, тосгон, уулс, ус, гол мөрөн, ваар сав, навчисын үзүүрт чичрэх шүүдрийн дусал гээд л бүгдийг гийгүүлнэ. Хүн сартай шөнө явж байхад сар араас нь үргэлж дагана. Саран авхай үл хувирна, гэвч өөр рүү нь харж буй хүнээс шалтгаалан хүн бүрт өөр өөр харагдана. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Тэрбээр хүмүүсийн араас үргэлж дагаж тэдний өмнө янз бүрийн дүр төрхөөр тодорно. Гэвч Бурхан багш мөнх оршиж, Тэрбээр үл хувирч өөрчлөгдөнө.

4. Бурхан энэ ертөнцөд учир шалтгааны улмаас буй болж, алга болдог. Хүмүүсийг аврах нөхцөл бүрдэхэд Тэрбээр энэ дэлхийд буй болно. Бүрдсэн нөхцөл арилахад Тэрбээр энэ дэлхийгээс халин одно.

Хэдийгээр Бурхан багш аливаа дүрийг

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

олохдоо төрж, үхдэг боловч үнэн хэрэгтээ Тэрбээр үл мэндэлж, үл үхнэ. Үүнийг ухаарч, Бурхан багшийн төрөх, үхэх хийгээд орчин тойрон байнга хувиран өөрчлөгдөж буйг харан гайхах, гуньж гутрахыг болих хэрэгтэй. Харин гэгээрч дээд зэргийн оюун ухааныг олвол зохино.

Бурхан багш бие махбодгүй, харин гэгээрэхийн биелэл юм. Бие махбод болбоос хоосон сав лугаа адил. Хэрэв энэ савыг гэгээрлээр дүүргэвэл Бурхан багш болно. Бие махбодыг Бурхан багш хэмээн сэтгэж, Түүний бие махбодын үхэлд уйтгарлан гашуудсан хүн жинхэнэ Бурхан багшийг олж харж үл чадна.

Үнэн хэрэгтээ юмс хоосон чанартай, тэдгээрийн хооронд өчүүхэн бээр ялгаа үгүй. Юмс төрөх, эвдрэх, ирэх, одох, буян нүглээс үл шалтгаалан оршино.

Юмсын ялгаа зөрөө нь тэдгээрийг харж буй хүмүүсийн буруу санаанаас үүднэ. Үүнтэй Бурхан багшийн дүр агаар нэгэн буй. Жинхэнэ Бурхан багш хэзээ ч буй болж, хэзээ ч үгүй болохгүй.

III

БУРХАН БАГШИЙН БОДЬ ЧАНАР

1. Бурхан багш дараах таван бодь чанартай учир түүнийг бүгд хүндэлдэг. Үүнд: биеэ зөв авч явах

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

чадвар, суут үзэл бодол, суут оюун ухаан, суут номлох чадвар, хүмүүсийг зөв замд оруулах суут чадвар багтана.

Түүнээс гадна Бурхан багш дараах найман чадвартай. Үүнд: нэгдүгээрт, Тэрбээр хүнд зол жаргал, сайн сайхныг авчирдаг. Хоёрдугаарт, Бурхан багшийн сургаал энэ ертөнцөд ашиг тус болдог. Гуравдугаарт, Тэрбээр нүгэл, буян, үнэн, худлын тухай зөв зүйтэй сургадаг. Дөрөвдүгээрт, Тэрбээр зөв зам мөрийн тухай зааж сургаад, хүмүүсийг гэгээрэлд залж авчирдаг. Тавдугаарт, Тэрбээр бүх хүнийг нэг л замаар дагуулан явдаг. Зургадугаарт, Бурхан багш биеэ тоох, онгирч сагсуурахыг үл мэднэ. Долдугаарт, Тэрбээр хэлсэн үгэндээ эзэн болж, юу хэлсэн яг түүндээ хүрдэг. Наймдугаарт, Тэрбээр өргөсөн тангараг, хүртсэн сахилаа заавал баримталж биелүүлдэг.

Бурхан багш бясалгалаар дамжин энх амгалан, амар тайван байдлыг олж, бүгдэд тэнцүүхэн энэрэнгүй бөгөөд нигүүлсэнгүй сэтгэлээр ханддаг. Тэрбээр атгаг сэтгэлээс бүрэн ангижирч, санаа сэтгэлээ муу муухайгаас чөлөөлж, зөвхөн ариун цагаан сэтгэлтэй хүний хүртэх тийм жаргал цэнгэлд хүрдэг.

2. Бурхан багш бол бүх хүний эцэг нь ч, эх нь ч

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

мөн. Мэндэлснээс нь хойш 16 сарын турш хүүхэдтэйгээ нялхын хэлээр нь ойлголцож, дараа нь том хүмүүсийн хэл зааж сургаж эхэлдэг эцэг эх лүгээ адил.

Бурхан багш хүмүүсийн ярьдаг хэлээр сургаалаа айлдаж, хүмүүсийн өмнө буй болохдоо тэдний таних дүрийг олж тодрон тэд нарыг амар амгалан, тайван ертөнцөд залж аваачдаг.

Бурхан багш сургаалаа нэг хэлээр номлох атал бүх хүн өөрийнхөөрөө ойлгож, Бурхан багш зөвхөн өөрт нь хандаж байна хэмээн боддог бүлгээ.

Бурхан багшийн сэтгэл санааг төөрөлдөгсөд үл ойлгоно, түүний үгээр илэрхийлэх аргагүй, гагцхүү сургаал домгоор тайлбарлаж болно.

Хэдийгээр Ганга мөрнийг яст мэлхий, загас жараахай, заан болон бусад ан амьтан бохирдуулж байдаг боловч ус нь цаг ямагт цэвэр цэнгэг байдаг. Үүнтэй Бурхан багш агаар нэгэн буй. Өөр шашин шүтлэгийн загас жараахай, яст мэлхий сүрэг сүргээрээ явж ус ундааг бохирдуулж булингартуулсан ч Бурхан багшийн Ном цэвэр цэнгэг, намуун тогтуун хэвээр үлдэнэ.

3. Бурхан багшийн оюун ухаан бүх үнэнийг мэднэ.

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

Бурхан багш аливаа туйлширлаас зайлсхийж ямагт дундад зам мөрийг баримталдаг юм. Аливаа бичиг үсэг, хэлээс хол давсан байдаг учир Тэрбээр хорвоогийн бүх хүний бодол санааг тод томруун уншиж нэгээхэн агшинд оюун ухаандаа орчлонт ертөнцийг бүхэлд нь багтаадаг.

Зах хязгааргүй тэнгис далайн усанд бүх од мичид багтан тусдагтай адил Бурхан багшийн оюун ухааны далайд бүх хүмүүсийн бодол санаа, бүх юмс нэгэн зэрэг тусмуй. Тиймээс Бурхан багшийг Бүхнийг мэдэгч хэмээдэг.

Бурхан багшийн оюун ухаан, хүмүүсийн санаа сэтгэлийн цангааг тайлж, тэдэнд гэрэл гэгээ хайрлаж, амьдралын утга учрыг номлож, цэцэглэн дэгжих болон мөхөн сүйрэх, учир шалтгаан болон үр дагаврын үнэнийг нээн харуулна. Гагцхүү Бурхан багшийн оюун ухааны дэмээр хүмүүс энэ хорвоог танин мэднэ.

4. Бурхан багш хүмүүсийн өмнө гагцхүү Бурхан багшийн дүрээр буй болдоггүй. Заримдаа Тэрбээр шулам, эмэгтэй хүн, бурхан, эзэн хаан, сайдын дүрээр ч тодордог. Тэрбээр янхан эм, мөрийтэй тоглогчийн гэрт ч залардаг.

Халдварт өвчин тархсан цагт Бурхан багш эмч

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

болж, бүгдэд эм тан тарааж, сургаал номоо хайрлана. Дайн дажин дэгдсэн цагт хүмүүсийг зовлон сүйрлээс аварч зайлуулахын тулд тэдэнд гэгээн сургаалаа айлддаг. Тэрбээр ганцхан үзлээ хатуу чанд баримтлах хүнд энэ ертөнцөд мөнхийн тогтонги юм үгүйг сургана. Тэрбээр биеэ тоож, амиа хичээсэн хүнд төлөв даруу байх, бусдын төлөө бие сэтгэлээ үл хайрлахыг номлоно. Тэрбээр энэ ертөнцийн зугаа цэнгэлд хууртсан хүнд хорвоогийн зовлон зүдүүр, аюул сүйрлийг үзүүлж харуулна.

Амьдралын аливаа тохиолдолд илрэх Бурхан багшийн бүх үйл хэрэг Дхармакая (Бурхан багшийн үнэмлэхүй мөн чанар)-гаас үүдэн гардаг. Бурхан багшийн эцэс төгсгөлгүй амьдрал, авралын эцэс төгсгөлгүй гэрэл гэгээ нь мөн адил Дхармакаягаас гарна.

5. Энэ ертөнцийн амьдрал шатаж буй байшинд байгаа мэт амар тайван бус. Хүмүүс мунхагийн харанхуйд автаж, хэрэлдэн уралцаж, атаа жөтөөнд өртөж, нэг нэгэндээ тунин гомдож, ертөнцийн шунал тачаал амьдралыг нь хиртээж хордуулна. Нялх хүүхдэд эх нь хэрэгтэйн адил хүмүүст Бурхан багшийн энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэл үгүйлэгдэнэ.

Бурхан багш ариун явдалтай бүхнээс хамгийн ариун явдалтай нь болой. Тэрбээр энэ орчлонгийн

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

эцэг нь юм. Тиймээс бүх хүн түүний үр хүүхэд юм. Тэд гагцхүү зугаа цэнгэл хөөцөлдөж, аюул сүйрлийг урьдчилан харах оюун ухаангүй юм. Энэ хорвоо зовлон зүдүүрээр дүүрэн, энд үргэлж өтлөж өвгөрөх, өвдөж зовох, үхэх мөхөхийн гал сүүмэлзэж байдаг юм.

Харин Бурхан багш төөрөгдөл бүхий, галд автсан ертөнцийн гадна, чимээ аниргүй ойд буй бөгөөд түүний айлдах нь:

"Энэ бол миний ертөнц, энд амьдарч буй хүмүүс цугаараа миний үр хүүхэд юм. Гагцхүү би тэднийг эцэс төгсгөлгүй зовлон зүдүүрээс аварч чадна".

Бурхан багш бол үнэхээр Номын агуу их хаан мөн. Тэрбээр сургаалаа хүссэнээрээ номлож чадна. Бурхан багш хүмүүсийг амарлингуй болгож, тэдэнд зол жаргал авчрахын тулд энэ ертөнцөд заларсан юм. Тэрбээр хүмүүсийг зовлон зүдүүрээс аврахын тулд Номоо номлодог. Гэвч хүмүүс хүсэл шуналаасаа болж түүний хэлснийг үл сонсож, түүнд анхаарлаа үл хандуулдаг юм.

Харин энэ сургаалыг сонсоод баярлаж баяссан хүмүүс шинэ ертөнцөд очиж тэндээс төөрөгдлийн мананд эргэж унахгүй. Бурхан багшийн хэлснээр "Миний сургаалыг зөвхөн түүнд сүсэглэн итгэсэн

Бурхан Багшийн Дүрүүд, Түүний Бодь Чанарууд

Хүмүүс хүлээн авч чадна. Гагцхүү Бурхан багшид сүсэглэн итгэснээр энэ сургаалыг ойлгохоос бус ухаанаар эс ойлгоно". Иймээс Бурхан багшийн сургаалыг анхааралтайяа сонсож, чанд мөрдвөөс зохино.

